

МУИС, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ №3 (132), 1997

Улаанбаатар хотын агаарын дээж дэх химийн элементүүдийн
найрлагыг цөмийн физикийн аргаар судлах нь

Н.Гансүх, Ш.Гэрбиш, А.Итгэлмаа, Ж.Сэрээтэр, М.Энхболд
(МУИС-ийн Цөмийн шинжилгээний төв)

Хот суурин газрын агаарын тоосжилтыг судлах хэд хэдэн шалтгаав байдаг. Үүнд: агаарын тоосны хэмжээ хүн амын эрүүл мэндэд нелөөлхүүж байх, агаарт байгаа цацраг идэвхт бодисын хэмжээг үнэлэх түүнчлэв атмосферийн доторх хувирал, шилжилт, тундасжилтын процессыг судлах зэрэг. Улаанбаатар хотын агаар нь нүүрсээр ажилладаг цахилгаан, дулааны станцууд, олон арван уурын зуух, 50 мянган гэрийн зуух болон олон арван мянган автомашинаас гарах дутуу шаталтын хий, утаа тортгоор бохирдож байна. Ялангуяа өвлүүн цагт нийслэл хотын агаар дахь нүүрстөрөгч, азот, хүхрийн ислүүдийн хэмжээ эрүүл ахуйн нормоос 1.5 - 2.6 дахин давж амьсгалын замын өвчин ихсэж байна гэж эрүүл ахуйн хяналтын ба байгаль орчныг хамгаалах байгууллагын мэдээнд дурьдсан байна.

Агаарын бохирдлогын дээж дэх цацраг идэвхт бодисын хэмжээг тодорхойлох талаарх судалгааг нэлээд хэдэн жилийн өмнөөс явуулж Улаанбаатар хотын агаар дахь цацраг идэвхт бодисыг бета идэвхээр нь тодорхойлж түүний хэмжээ жилийн сар, улирлын байдлаас ихээхэв хамаардагийг үзүүлсэн байна.

Гэвч нийслэл болон манай орны үйлдвэрийн томоохон төвүүдийн агаарын бохирдлогын дээжинд хүнд металл ба хортой химийн элементүүдийн найрлага, хэмжээг одоо хүртэл тодорхойлоогүй байна. Манай улс 1996 оноос Олон Улсын Атомын Энергийн Агентлаг (ОУАЭА), Зүүг өмнөт Ази ба Номхон далайн орнуудын бусийн гэрээ (RCA)-кийн хүрээнд Азийн томоохон хотуудын агаарын бохирдлогыг судлах хамтын эрдээ шинжилгээний төсөлд оролцон зохих төхөөрөмж авч суурилуулж шинжилгээний ажил эхэлж байна. 1996 оны 10-р сард МУИС-ийн төв байранд агаарын дээж авах PM10 төхөөрөмжийг угсарсан юм. Үг төхөөрөмжийн агаарын тоос цуглуулах хэсэг нь цөмийн фильтр (шүүр) гэгдэх 47 мм диаметр бүхий давхар байрлуулсан поликарбонад хальс юм Тасалгаан дотор байрлах төхөөрөмжийн хэсэгт агаар сорох насос, вакуум хэмжигч, агаарын ургал болон нийт сорогдсон агаарын эзэлхүүн хэмжигчүүд багтана.

Агаарын дээж авалтыг 24 цагийн хугацааны программчилсан залгагчийн тусламжтайгаар хянаж, сорж буй агаарын ургалын хэмжээг 1 минутанд 15-16 литр байхаар тохируулна. Цөмийн фильтрийн жинж тодорхойлоходоо 1 мкг -ын нарийвчлалтай электрон жигиүүр ба цахилгаав статик цэнэгийг саармагжуулагч ^{210}Po бүхий цацраг идэвхт үүсгүүр ашигладаг.

Агаарын тоосны дээж авах төхөөрөмжийг 1996 оны 10 сард байрлуулсан 11 сараас дээж авч эхэлсэн боловч төхөөрөмж ажиллах эхэлснээс хойш 1-2 цагийн дараа сорогдож буй агаарын хэмжээ огцом буурч байв. Энэ нь Монгол орны хүйтэн, хуурай цаг агаарын өвөрмөц нөхцлийн шалтгаалан агаарт маш жижиг мөсөн кристалл бүтэц үүсч тэр нь нарийн

шүүрийн нүхийг таглаж болох юм гэсэн таамаглал нь туршлагаар батлагдсан тул сорогдож буй агаарыг халаах агаар халаагч хэрэгсэл угсарч байрлуулав. Агаар халаагч хэрэгсэл нь вольфрам спираль угас ороосон кварц хоолой бөгөөд дамжуулагчаар гүйх гүйдлийн хүчийг тохируулах замаар кварц хоолойн доторх агаарын температурыг зохих хэмжээнд байлгахад зориулагдсан юм. Цаашид агаарын температурын өөрчлөлтөөс замааруулан дамжуулагч утсанд өгөх хүчдэлийг автоматаар өөрчлөх багаж зохион бүтээх шаардлагатай болно.

Агаарын тоосны дээж авалтыг ОУАЭА ба RCA-ын шугамаар боловсруулсан стандарт заавар, удирдамжийг удирдлага болгон гүйцэтгэсэн болно [1-3]. Нэг кубметр сорогдсон агаарт ногдох фильтр дээр цутларсан тоосны хэмжээ нарийн (нүхний диаметр 0.4 мкм) ба бүдүүн (нүхний диаметр 0.8 мкм) фильтрүүдэд харгалзан 15-20 ба 60-70 мкг байв. Энэ замжээ нь дээж авах стандарт шаардлагыг хангаж байгаа юм. Бид энэ урьдчилсан хэмжилтэнд цэвэр фильтр ба тоос хуримтлагдсан фильтрийн жижиг 5-10 мкг нарийвчлалтай электрон жигнүүрээр жигнэсэн ба цэнэг шаармагжуулагч хэрэглээгүй учир тоосны жин нь 25 орчим %-ийн алдаатай болсон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Цемийн фильтр дээр хуримтлагдсан агаарын тоосны дээж дэх химийн элементүүдийн найрлага, хэмжээг тодорхойлоход рентген хоолойтой ба ^{241}Am цацраг идэвхт изотоп үүсгүүр бүхий рентген флуоресценцийн спектрометр(XRF) ба бүрэн ойлтын рентген флуоресценцийн спектрометр(TRXF) хэрэглэсэн болно.

Агаарын тоосон доторх химийн элементүүдийн найрлагыг бүрэн ойлтын рентген флуоресценцийн спектрометр ашиглан тодорхойлохдоо фильтрээсээ хэсэглэн авч шууд хэмжсэн болно. 1-р зураг дээр нарийн фильтр дээрх тоосон дахь элементүүдийн спектрийг харуулж байна. Энэ зургаас үзвэл S, K, Ca, Ti, Cr, Mn, Fe, Cu, Zn, As, Br, Sr, Pb зэрэг элементүүд харагдаж байна. Тухайн хэмжилтийн нөхцөлд элементүүдийн тоон хэмжээг тодорхойлох боломжгүй учир РФА аргаар стандарт дээжүүд ашиглан тоон хэмжээг нь тогтоосон уг дээж дэх тэмрийн агуулгатай жишиж тодорхойлсныг 1-р хүснэгтэд үзүүлэв. Агаарын тоосны фильтрийг AAS, TRXF, ISP-MS аргуудаар шинжлэхдээ цемийн фильтрийг уусгах тусгай боловсруулсан аргыг хэрэглэдэг байна [4]. Энэ аргаар цаашид цемийн фильтрийг боловсруулан шингэн байдалд оруулан дээж дэх химийн элементүүдийн агуулгыг TRXF аргаар тодорхойлох юм.

Цаасан фильтр ашиглан авсан Улаанбаатар хотын агаарын бохирдлын үзэжийг протоноор өдөөж рентген цацрагийг нь бүртгэх (PIXE) аргаар[5] Сингапурын үндэсний их сургууль дээр хэмжсэн юм. Энэ аргаар хэмжсэн спектрийг 3-р зураг дээр харуулав. Улаанбаатар хотын агаарын бохирдлогын үзэж дэх химийн элементүүдийн хэмжээг Сингапур хотынхтай харьцуулан 1-р хүснэгтэд үзүүлэв.

Агаарын тоосны дээжийг цемийн фильтрийн тусламжтайгаар авч элементүүдийн найрлага, агуулгыг урьдчилан тодорхойлсон байдлаас үүгнэвэл:

- Тодорхойлсон элементүүдийн найрлагаас үзэхэд нийслэл хотын агаарын бохирдлого нь нүүрсээр ажилладаг дулаан, цахилгааны станцууд, тээврийн хэрэгслийд, хог хаягдлын шаталт, хөрсний звдрэл зэрэг олон эх


Үүсгүүртэй болох нь харагдаж байна. Цаашид бохирдлогын эдгээр үүсгэврийн хувь хэмжээг тогтоох нь чухал болно.

2. Цөмийн фильтр хэрэглэснээр ердийн тоосны шүүлтүүрт үл шүүгдэх нарийн тоосны (2 микронос бага) хэмжээг ялган тодорхойлох бололцоотой болж байна. Чухамхүү энэ нарийн тоос нь амьсгалын замын өвчний эх Үүсгүүр болдог билээ.
3. Цөмийн физикийн аргыг агаарын бохирдлогын шинжилгээнд нэвтрүүлэх нь агаар дахь хүнд болон хүний эрүүл мэндэд хортой элементүүдийн хэмжээг тогтоож тэдгээрийн нөлөөг багасгах арга замыг боловсруулахад чухал ач холбогдолтой болно.


Ишлэл хийсэн ном, зохиол

1. W.Maenhaut, F.Francocis and J. Cafineyer
The "Gent" Stacked Filter Unit Sampler for Collection of Atmospheric aerosols in two size fractions: Description and Instructions for Installation and Use. Applied Research on Air Pollution Using Nuclear-Related Analytical Techniques.
Reports on the First Research Co-ordination Meeting, Vienna, Austria, 1994. IAEA, pp. 249-263
2. P.K.Hopke, Ying Xie and T.Raunemana
Characterization of the Gent PM10 Sampler. Applied Research on Air Pollution Using Nuclear-Related Analytical Techniques.
Report on the Second Research Co-ordination Meeting , Menai, Austria, 1995, pp. 18.1-18.7
3. Sampling and Analytical Methodologies for Instrumental Neutron Activation Analysis of Airborne Particulate Matter.
Training Course Series No 4, IAEA, 1992
4. L.M.Jalkanen and E.K. Hasanen
Simple Method for the Dissolution of Atmospheric Aerosol Samples for Analysis by Inductively Coupled Plasma Mass Spectrometry.
Journal of Analytical Atomic Spectrometry Vol. 11 (1996), pp.365-369
5. I.Orlic, Bao Wenlan, F.Watt and S.M.Tang
Air Pollution in Singapore: Its Multielemental Aspect as Mesasured by Nuclear Analytical Techniques.
Paper presented on the 5 th Symposium on Our Environment, Singapore 5-7 June 1995. pp.1-16.

MCA #1 - Canberra System 100 - airfilter fine solution
 Tag Number : 191 Plotted On : Fri 06 Jun 1997 @ 19:48:27
 Dead Time : 0.00% Acquire Started : Tue 13 Sep 1988 @ 08:58:27




1/16 :VFS= 4096



Cursor=148	From 142	To 148	Pset(LS)=	2000.00
Counts=424	Int=2073	Area=0+-0.00%	Elap(LS)=	200.00

1-p 3ypar



Д/д элмент	Пикийн талбай (Fe-аар нормчилсон)	Элементүүдийн аргуулга (%)
1. K	0.0622 ± 0.0009	0.10 ± 0.02
2. Ca	0.190 ± 0.001	0.30 ± 0.07
3. Ti	0.0335 ± 0.0006	0.05 ± 0.01
4. Mn	0.0180 ± 0.006	0.03 ± 0.01
5. Fe	1.000 ± 0.0035	1.6 ± 0.4
6. Cu	0.0115 ± 0.0006	0.018 ± 0.004
7. Zn	0.0225 ± 0.0008	0.035 ± 0.009
8. Rb	0.008 ± 0.001	0.012 ± 0.003
9. Sr	0.0256 ± 0.0017	0.04 ± 0.01
10. Pb	0.0222 ± 0.0016	0.034 ± 0.009

1-р хүснэгт

Concentration +/- Error (ng/cm²)

	No6a	No6b	03-Feb-97-F	03-Feb-97-C
Na	651 +/- 24	809 +/- 32	35 +/- 9	40 +/- 6
Mg	912 +/- 25	1146 +/- 34	13 +/- 9	17 +/- 7
Al	14764 +/- 47	18108 +/- 210	86 +/- 10	284 +/- 10
Si	40447 +/- 73	49291 +/- 559	207 +/- 11	791 +/- 19
P	0 +/- 0	0 +/- 0	0 +/- 0	0 +/- 0
S	14618 +/- 63	16623 +/- 206	2660 +/- 24	483 +/- 14
Cl	920 +/- 37	1107 +/- 55	56 +/- 14	161 +/- 10
K	5640 +/- 57	6775 +/- 109	377 +/- 16	199 +/- 12
Ca	18209 +/- 134	21333 +/- 317	66 +/- 11	638 +/- 21
Sc	0 +/- 0	217 +/- 90	0 +/- 0	0 +/- 0
Ti	1638 +/- 45	1934 +/- 61	13 +/- 7	29 +/- 6
V	0 +/- 0	0 +/- 0	0 +/- 0	0 +/- 0
Cr	108 +/- 27	68 +/- 32	9 +/- 5	0 +/- 0
Mn	520 +/- 31	571 +/- 38	0 +/- 0	9 +/- 4
Fe	12892 +/- 113	15207 +/- 270	107 +/- 9	290 +/- 13
Co	0 +/- 0	0 +/- 0	0 +/- 0	0 +/- 0
Ni	16 +/- 7	27 +/- 9	3 +/- 2	3 +/- 2
Cu	58 +/- 8	73 +/- 10	18 +/- 3	53 +/- 4
Zn	298 +/- 14	368 +/- 18	40 +/- 5	27 +/- 3
Ga	21 +/- 7	17 +/- 8	0 +/- 0	0 +/- 0
As	85 +/- 16	71 +/- 20	0 +/- 0	0 +/- 0
Br	0 +/- 0	0 +/- 0	39 +/- 10	45 +/- 11
Pb	579 +/- 49	681 +/- 60	44 +/- 13	38 +/- 10